



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

318.	2013 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай	Дугаар 179	1361
319.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 181	1364

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

#### **2013 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай**

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн 2013 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Ц.БАЯРСАЙХАН**



Засгийн газрын 2013 оны 179 дүгээр  
тогтоолын хавсралт

2013 ОНД ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

№	Аймаг, нийслэл	Өмчлүүлэх газрын байршил	Иргэнд өмчлүүлэх нийт газрын хэмжээ (га-гаар)	Өмчлүүлэх газрын зориулалт (га-гаар)						Үүнээс		
				Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээ	Шийэр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Улсын чанартай авто замын дагуух газар өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үр тарианы	Тамс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар	
1	Архангай	Аймгийн болон сумын төвд	237.47	237.44	128.25	102.82	6.37	0.03	0.00	0.00	0.00	0.03
2	Баян-Өлгий	Аймгийн болон сумын төвд	245.93	245.13	153.01	92.12	0.00	0.80	0.00	0.00	0.00	0.80
3	Баянхонгор	Аймгийн болон сумын төвд	46.56	46.56	23.90	22.66	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Булган	Аймгийн болон сумын төвд	1245.76	823.82	167.48	641.89	14.45	421.94	390.00	30.94	1.00	1.00
5	Говь-Алтай	Аймгийн болон сумын төвд	44.50	43.50	9.98	33.52	0.00	1.00	0.00	1.00	0.00	0.00
6	Дархан-Уул	Аймгийн болон сумын төвд	279.37	279.37	193.73	46.44	39.20	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Дорноговь	Аймгийн болон сумын төвд	16.47	16.47	0.00	16.47	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дорнод	Аймгийн болон сумын төвд	381.95	381.95	26.6	355.35	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	Дундговь	Аймгийн болон сумын төвд	107.40	107.40	24.58	73.51	9.31	0.00	0.00	0.00	0.00	0.00
10	Завхан	Аймгийн болон сумын төвд	342.74	331.94	211.79	120.15	0.00	10.80	0.00	0.00	0.00	10.80

11	Орхон	Аймгийн болон сумын төвд	52.52	52.52	24.80	27.72	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Өвөрхангай	Аймгийн болон сумын төвд	197.36	197.08	30.50	137.48	29.10	0.28	0.00	0.00	0.00	0.28
13	Өмнөговь	Аймгийн болон сумын төвд	893.49	887.49	6.01	860.48	21.00	6.00	0.00	0.00	6.00	0.00
14	Сүхбаатар	Аймгийн болон сумын төвд	168.08	167.37	62.82	104.55	0.00	0.71	0.00	0.00	0.00	0.71
15	Сэлэнгэ	Аймгийн болон сумын төвд	1427.04	1150.99	331.26	705.11	114.62	276.05	248.00	21.00	21.00	7.05
16	Төв	Аймгийн болон сумын төвд	2382.67	2382.67	173.97	1937.74	270.96	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	Увс	Аймгийн болон сумын төвд	257.04	243.93	124.86	119.07	0.00	13.11	12.60	0.00	0.00	0.51
18	Ховд	Аймгийн болон сумын төвд	495.62	495.62	102.65	392.97	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
19	Хөвсгөл	Аймгийн болон сумын төвд	325.00	323.83	294.40	29.43	0.00	1.80	0.00	0.00	0.00	1.80
20	Хэнтий	Аймгийн болон сумын төвд	420.25	420.25	85.34	334.91	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
21	Нийслэл	Нийслэлд	102.95	102.95	68.75	34.2	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
		Дүн	9670.17	8938.28	2175.93	6154.39	505.01	732.52	650.60	58.94	22.98	



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 5 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар  
хот

### Журамд нэмэлт оруулах тухай

Боловсролын тухай хуулийн 39.7, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-д дор дурдсан агуулгатай “3.3.7”, “4.2.5” дахь заалт тус тус нэмсүгэй:

1) 3.3.7. дахь заалт:

“3.3.7. багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуулийн хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх зохих шаардлага хангасан суралцагчид 100 хувийн.”

2) 4.2.5. дахь заалт:

“4.2.5. төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь.”

2. Энэ тогтоолыг 2013-2014 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны төсвийн багцаас, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

**Индекс: 14003**